

"Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй ил тод байдал" мониторингийн 1-р шатны тайлан

Гарчиг

1. Мониторингийн арга зүй

- 1.1 Мониторингийн шаардлага
- 1.2 Мониторингийн зорилго
- 1.3 Мониторингийн зорилт
- 1.4 Мониторингийн зохион байгуулалт

2. Мониторингийн аргачлал

- 2.1 Мэдээлэл бүрдүүлэх аргууд
- 2.2 Хамрах хүрээ, хугацаа

3. Мониторингийн үр дүн:

- 3.1 Шууд утасны /1977/ судалгааны үр дүн
- 3.2 Авлигатай Тэмцэх Газраас төрийн байгууллагуудын мэдээллийн хүртээмжийг сайжруулахаар хүргэсэн зөвлөмжийн хэрэгжилт
- 3.3 Авлигатай Тэмцэх Газраас төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй байдлыг сайжруулахаар хүргэсэн зөвлөмжийн хэрэгжилт
- 3.4 Авлигатай Тэмцэх Газраас төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах чиглэлээр хүргэсэн зөвлөмжийн хэрэгжилт

4. Дүгнэлт

Хавсралт

- Авлигатай Тэмцэх Газрын зөвлөмж
- Ажиглалтын судалгааны харьцуулсан мэдээлэл
- Зөвлөмжийн хэрэгжилт сул байгууллагуудын нэрс

1. МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ

1.1 Мониторингийн шаардлага

Ардчилсан засаглалын гол шалгуур үзүүлэлт нь: “Тухайн улсын төрийн байгуулал хэр ардчилсан байна вэ?” гэсэн энгийн боловч маш тодорхой асуудал байдаг. Үүнийг хангах гол механизм нь төрийн байгууллагын нээлттэй, ил тод байдал бөгөөд нээлттэй мэдээлэл бол сайн засаглалын суурь, ардчилсан нийгмийн амин сүнс юм.

Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт: “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих, нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” хэмээн иргэнийхээ эрхийг баталгаажуулахын зэрэгцээ хуульд өөрөөр заагаагүй бол ил тод байх, ард түмэнд үйлчлэхийг төрийн албаны үндсэн зарчмуудын нэг байхаар Төрийн албаны тухай хуульд заасан байна.

НҮБ-ын тусгай илтгэгч “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний” талаар 2000 онд тавьсан илтгэлдээ: “Хууль тогтоомжид мэдээллийг боломжийн түвшинд, нээлттэй, ил тод болгох тухай заалт оруулах, төрийн байгууллага нь өөрийн санаачилгаар үндсэн мэдээллээ нийтлэх, мэдээлэл нээлттэй байх зарчимд үл нийцэх, хууль тогтоомжийг өөрчлөх” шаардлагатайг цохон тэмдэглэсэн.

Манай улс 2003 онд болсон “Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон” улсуудын олон улсын 5-р бага хурлын үеэр баталсан “Улаанбаатарын тунхаглал”-д “Ардчилал бол нээлттэй, ил тод нийгэм” болохыг тунхаглаж, “Нээлттэй, ил тод нийгэм мэдээлэл чөлөөтэй бүрдүүлэх, эрэлхийлэх болон түгээхийг “хөхиүлэн дэмжинэ” гэж амлажээ.

2002 онд “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага Лондон хотноо төвтэй олон улсын “19-р зүйл” (ARTICLE 19) байгууллагатай хамтран шилжилтийн үеийн Монгол улсын “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиудад” хийсэн задлан шинжилгээний тайланд: “Монгол улсад төрийн байгууллагын нээлттэй байдал хангалтгүй байгаа нь гол бэрхшээл юм” хэмээн тэмдэглэсэн байна.

2002 онд УИХ-аас баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2.3-р зүйлд: “Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, нийгмийн шударга ёс, тэгш байдлыг хангах, олон нийтэд ил тод байх, бусад улс, олон улсын байгууллагын дэвшилтэт арга, туршлагыг харгалзах зарчмыг баримтална” гэжээ.

Монгол Улс Авилгын эсрэг Олон Улсын конвенцид нэгдэн орж, 2006 оны 07 сарын 06-ны өдөр Авилгын Эсрэг Монгол Улсын хууль батлагдаж, Авлигатай Тэмцэх Газар /цаашид “АТГ” гэх/ байгуулагдсан билээ.

Авлигын эсрэг хуулийн олон нийтийг соён гэгээрүүлэх /5-р зүйл/, Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа /6-р зүйл/, өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх /9-

р зүйл/, АТГ-ын чиг үүрэг, бүрэн эрх /18-р зүйл/-ийн хүрээнд АТГ-аас “Төрийн байгууллагын хүнд суртлыг багасгах, төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, улмаар авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийг ил тод байлгах, үйл ажиллагаагаа нээлттэй болгох, иргэдийн оролцоог хангах” талаар 18 зүйл бүхий зөвлөмж бичиг боловсруулж, 2007 оны 4-р сард төрийн байгууллагуудад хүргүүлжээ.

АТГ-аас хүргүүлсэн дээрх зөвлөмжийн хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагын /Глоб Интернэшнл/ зүгээс хийж буй “Төрийн байгууллагын нээлттэй, ил тод байдлын мониторинг” төслийг АТГ-ын захиалга, Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр хагас жилийн хугацаатайгаар хэрэгжүүлж байна.

1.2 Мониторингийн зорилго

АТГ-аас гаргасан зөвлөмжийн дагуу Төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгох чиглэлээр төрийн байгууллагууд хэрхэн ажиллаж байгаа талаар бодит мэдээлэлтэй болох, уг мэдээлэлдээ тулгуурлан зөвлөмжийн хэрэгжилтийн түвшин, хэрэгжүүлэхгүй байгаа шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйлсийн талаарх дүгнэлт, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн цаашид авах шаардлагатай арга хэмжээний санал бүхий ерөнхий зөвлөмж боловсруулахад оршино.

1.3 Мониторингийн зорилт

- АТГ-аас гаргасан зөвлөмжийн хүртээмж, хэрэгжих боломж нөхцөлд үнэлгээ өгөх
- Зөвлөмжийн хэрэгжилтийн түвшинг тогтоох, төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын төлөв байдлыг тодорхойлох
- АТГ-аас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтэд учирч буй саад бэрхшээл, шалтгаан нөхцөлийг илрүүлэх
- Төрийн байгууллагуудын үйлчилгээний ил тод, хүртээмжтэй байдлыг сайжруулах, иргэдийн оролцоог хангахын тулд цаашид шийдвэрлэх арга замыг тодорхойлох

1.4 Мониторингийн зохион байгуулалт

Мониторингийн баг бүрдүүлэх

Мониторингийн баг нь анализийн баг, тандах судалгааны баг гэсэн бүтцээр ажиллаж байна. Арга зүй, анализийн баг нь зөвлөх, хоёр судлаачийн бүрэлдэхүүнтэй. Тандах судалгааны баг нь мэдээлэл цуглуулах 11 мониторингч, мэдээлэл оруулах, боловсруулах хоёр мониторингч, шууд утсаар мэдээлэл хүлээн авах нэг мониторингч, төслийн зохицуулагч, нийт 18 гишүүнтэй ажиллаж эхлэв.

Мониторингийн арга зүй боловсруулах, арга зүйн сорил

Мониторингийн арга зүйг анализийн баг 2007 оны 7 сард багтаан боловсруулж, арга зүйн дагуу боловсруулсан анкет, асуулга бүрээр сорил хийж, анкетуудыг эцэслэн боловсруулав.

Мониторч бэлтгэх нэг өдрийн сургалт

Мониторингийн мэдээлэл цуглуулах, боловсруулах дадлага, чадвар эзэмшүүлэх нэг өдрийн сургалтыг 2007 оны 8 сарын 11-ний өдөр зохион байгуулав. “Глоб Интернэшнл” ТББ, тэргүүн Х.Наранжаргал төслийн танилцуулга, үндэслэлийг тайлбарлаж, хуульч Г.Даваахүү “Нийтэд ил тод байх мэдээлэл, түүний хууль зүйн үндэслэл”, хуульч Д.Мөнхбүрэн “Авлига гэж юу вэ? Түүний түгээмэл хэлбэрүүд”, Авлигатай тэмцэх газрын ахлах ажилтан Х.Доржпалам “Төрийн байгууллагуудын чиг үүрэг. Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн мөн чанар, агуулга”, судлаач Г.Цогтбаатар “Социологийн судалгааны арга зүй ба үр дүнгийн үзүүлэлт, Ил тод байдлын судалгааны хүрээ, онцлог, мөн чанар, мониторингийн аргачлал, Судалгааны маягтын дагуу мэдээллийг хэрхэн үр дүнтэй, бүрэн” сэдвүүдээр хичээл заасан.

2. МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ

Мэдээлэл бүрдүүлэх аргүүд

Ажиглалтын судалгаа: Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэг бүхий байгууллагууд иргэдэд шаардлагатай мэдээллийг хэр зэрэг хүртээмжтэй түгээж байгааг тодруулах зорилгоор зөвлөмж бичгийг дотор нь нэг бүрчлэн нарийвчлан задалж, асуулт боловсруулсны дагуу байгууллагуудад ажиглалт хийлээ.

Сурвалжилгын судалгаа: Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудад ажиллаж буй ажилтан, албан тушаалтнуудаас тухайн байгууллагад АТГ-аас хүргүүлсэн зөвлөмж хэрэгжиж байгаа эсэхийг асууж лавлан, хэрэв хэрэгжиж байгаа бол ямар түвшинд байгаа, үгүй бол яагаад гэдгийг тодруулсан болно.

Бичиг баримтын шинжилгээ: Төрийн үйлчилгээний байгууллагууд иргэдэд хүргэх үйлчилгээний талаарх тараах материал болон Вэб сайт дахь мэдээллүүд зэргийг нь судлан үзэж бичиг баримтын судалгааг хийв.

Шүүд үтас ажиллуулах: Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдалтай холбоотой иргэдээс гомдол, санал хүлээн авч судалгаа хийв.

Мониторингийн хүрээ

Мониторинг хийх төрийн байгууллагын тоог анх төлөвлөснөөс 2 дахин нэмэгдүүлж судалгаанд хамруулсан. Байгууллагын тоог нэмэгдүүлж, хамрах хүрээг өргөжүүлсэн үндэслэл нь төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх байгууллагыг салбар, тогтолцоогоор нь системтэй авч үзэх, мөн дээд шатны байгууллага болон анхан шатны байгууллагын хоорондох ажлын уялдаа холбоо, иргэдэд үйлчлэх үйлчилгээний хүртээмжийг цогц байдлаар олон талаас нь авч үзэх нь илүү үр дүнтэй гэж үзсэн.

Судалгаанд нийт 110 төрийн байгууллага, албан тушаалтан, ажилтан, 330 иргэнийг хамруулахаас:

- ажиглалтын судалгаанд 107 байгууллага,
- сурвалжилгын судалгаанд 104 албан тушаалтан, 106 ажилтан,
- төрийн байгууллагаас үйлчилгээ хүртэгч 319 иргэнийг тус тус мониторингийн судалгааны эхний шатанд хамрууллаа.

Нийт 3 байгууллага, 6 албан тушаалтан, 4 ажилтан судалгаанд оролцохоос татгалзан тус тусын шалтгаанаа доорхи байдлаар тайлбарлалаа. Судалгаанд оролцох байгууллага тоо хасагдсанаас шалтгаалан түүгээр үйлчлүүлэгч иргэдийн тоо хасагдсан. Судалгаанд оролцохоос татгалзсан үндэслэлийг дараах байдлаар тайлбарласан байна.

Эдгээрт:

Татгалзсан байгууллага:

- Нийслэлийн ОБГ нь иргэдэд үйлчилдэггүй, тусгай статустай байгууллага учир аливаа нэгэн судалгаанд хамрагдах боломжгүй гэж тайлбарласан.
- ТӨХ нь төрийн мэдэлд байгаа өмчийн харилцааг зохицуулах бөгөөд иргэдтэй шууд тулж ажилладаггүй тул иргэдээс судалгаа авах боломжгүй байлаа.
- ШБӨХЗГ нь иргэдтэй шууд харилцдаггүй бөгөөд зөвхөн монополь компаниудын асуудлыг зохицуулдаг засгийн газрын тохируулагч агентлаг тул дээрхийн адил иргэдээс судалгаа авах боломжгүй байв.

Татгалзсан албан тушаалтнууд:

- БГД-ийн ШШГА-ны ахлах гүйцэтгэгч Ч.Оюунцэцэг “Манай байгууллагад АТГ-аас зөвлөмж ирээгүй тул судалгаа өгөхгүй” хэмээн татгалзсан.
- ГССҮТ-ийн дарга одоо завгүй байгаа тул судалгааг дараа өгье гээд дахин уулзах ба утсаар холбогдох боломж олгоогүй болно.
- БГД-ийн ТХ-ийн хэлтсийн дарга амарсан гээд нарийн бичгийн дарга нь судалгаанд хамрагдах боломжгүй гэсэн албан тоот хийж өгсөн.
- СБД-ийн Шүүхийн хяналтын прокурор Энхтуяа “Наад судалгаа чинь манай байгууллагатай ямар холбоотой юм бэ?, дүүргийн прокуророос очиж асуу. Даргын зөвшөөрөлгүй ямар ч судалгаа өгөхгүй, байгууллагадаа ч оруулахгүй” гээд судалгаа авахаар очсон мониторингийг харуулаа дуудаж хөөж гаргуулсан байна.
- СХД-ийн НДХ-ийн албан тушаалтан нь дарга амарсан тул энэ судалгаанд оролцох боломжгүй хэмээн албан тоот өгсөн болно.
- НОБГ-аас албан тушаалтан судалгаанд оролцоогүй.

Татгалзсан ажилтнууд:

- БГД-ийн ШШГА-ны ажилтан даргын зөвшөөрөлгүйгээр судалгаанд хамрагдах боломжгүй хэмээн татгалзав.
- СХД-ийн НДХ-ийн албан тушаалтан судалгаанд оролцохгүй хэмээн албан тоот өгсөн тул ажилтан нь мөн хамрагдаагүй болно.
- ГССҮТ-ийн дарга судалгаанаас татгалзсан тул ажилтан нь мөн адил татгалзсан.
- НОБГ-ын ажилтнаас судалгаа авах боломжгүй байлаа.

1977 шууд утасны судалгаанд өнгөрсөн долдугаар сард 46 гомдол, 4 санал, наймдугаар сард 83 гомдол, 6 саналыг иргэдээс ирүүллээ.

Мониторингийн хугацаа

Мониторингийн судалгаа 2007 оны 07 сарын 01-ээс 2007 он дуустал зургаан сарын хугацаанд үргэлжилнэ. Мониторингийн тандалт, сурвалжлагын мэдээллийг

найм, аравдугаар саруудад цуглуулж, суурь мэдээллээ бүрдүүлэн, хоёр сар тутамд судалгааны явцын үр дүнг хэвлэлийн бага хурлаар дамжуулан олон нийтэд мэдээлж, ингэснээр төрийн үйлчилгээг иргэдэд илүү ойр болгоход түлхэц болох юм.

Мониторингийн эхний шатны судалгааг 2007 оны 8-р сарын 06–10–ны хооронд ажлын таван өдөрт багтаан, нийслэл хотод байрлалтай төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэг бүхий улс, нийслэл, дүүргийн эрх хэмжээтэй байгууллагуудад хийлээ.

Бичиг баримтын шинжилгээгээр дамжуулан, байгууллагын чиг үүргийг судлах ажлыг төсөл эхэлснээс хойшхи хоёр сарын хугацаанд хийж гүйцэтгэв.

1977 шууд утасны судалгаа нь 2007 оны 7 дугаар сарын 9-нөөс эхэлж, энэ оны 12 сар дуустал үргэлжилнэ.

3. МОНИТОРИНГИЙН ҮР ДҮН

3.1 Шууд утасны судалгаа /7-8 дугаар сарын байдлаар/

Төслийн хүрээнд төрийн байгууллагуудын зүгээс иргэдэд үзүүлж буй үйлчилгээнд гарсан зөрчлийн талаархи иргэдийн санал, гомдлыг хүлээн авах АТГ-ын 1977 (энгийн утасны тарифтай) шууд утсыг 7-р сарын 9-нөөс нээлттэй ажиллуулж байгаа ба ирсэн мэдээллийг 7 хоногийн лхагва, баасан гарагуудад нэгтгэж, Авилгатай Тэмцэх Газарт хүргүүлдэг.

АТГ эдгээр гомдлыг судлаж үзээд, тухайн гомдолд дурьдагдсан байгууллага, албан тушаалтанд зөрчлөө нэн даруй арилгаж, арга хэмжээ авахыг сануулсан шаардлага хүргүүлж, улмаар ямар арга хэмжээ авсан тухайгаа эргээд мэдээлэх үүрэг өгөн ажиллаж байна. Утасны судалгааны үр дүнг АТГ болон “Глоб Интернэшнл” ТББ-ын вэб сайтаар дамжуулан олон нийтэд сар тутамд танилцуулж байна.

Өнгөрсөн хоёр сарын хугацаанд 1977 шууд утсаар төрийн үйлчилгээний байгууллагын албан тушаалтан, ажилтнуудтай холбоотой 129 гомдол, 9 санал ирүүлсэн байна. Гомдол ирүүлсэн иргэдийг харьяаллаар нь авч үзвэл 90,85 % нь УБ хотоос, үлдэх 9,15% нь орон нутагт оршин суугч байв.

ХХҮГ, ЭМБ, БГ зэрэг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтан, хэлтэс, салбарын дарга нар болон бүх шатны шүүгч, прокурор, мэргэжлийн хяналтын байцаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, цагдаа, гаалийн байцаагч зэрэг иргэдтэй шууд тулж ажилладаг төр захиргааны гүйцэтгэх албан тушаалтнууд, төрийн тусгай байгууллагын албан тушаалтнуудын үйл ажиллагаатай холбоотой гомдлууд үнэмлэхүй хувийг эзэлж байна.

Иргэдийн гомдлыг байгууллагаар нь авч үзвэл *долдугаар сард* газрын албад 14,3 хувь, нийслэл, дүүргийн ЗДТГазрууд 28,6 хувь, ШШБАлбад 7,1 хувийг эзэлсэн бол, наймдугаар сард 21,7 хувь ЗДТГазрууд, 10,8% хувь ЗЦХэлтэсүүд, 7,2 хувь ШШБАлбадыг иргэдийг чирэгдүүлж, зөрчил гаргажээ.

Гомдол гаргасан үндэслэлээ иргэдийн 29,1 хувь нь хүнд суртал чирэгдэлтэй байна, 26,8 хувь нь хуулийн дагуу асуудал шийдэж өгөхгүй байна, 18,1 хувь нь хуулийн хугацаанд шийдэж өгөхгүй байна, 11 хувь нь албан тушаалаа урвуулан ашиглаж, улсын болон бусдын эд хөрөнгийг завшиж байна хэмээн тайлбарласан байна.

1. Авлигатай Тэмцэх Газраас төрийн байгууллагуудын мэдээллийн хүртээмжийг сайжруулахаар хүргэсэн зөвлөмжийн хэрэгжилт

Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэг бүхий байгууллага өөрийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журмаа үйлчлүүлэгчдэд харагдахаар газарт байрлуулах -1

Судалгаанд хамруулсан байгууллагуудын 54.2 хувь нь буюу 58 байгууллага дүрэм журмаа үйлчлүүлэгчдэд харагдахаар газарт байрлуулсан байв. Тэдгээр байгууллагыг үйл ажиллагааных нь төрлөөр харьцуулбал иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх байгууллагууд, санхүү, татвар, гаалийн байгууллагуудад АТГ-ын зөвлөмж-1 ийн хэрэгжилт харьцангуй сул байлаа. Түүнчлэн эрх хэмжээний хувьд нийслэл буюу дунд түвшний байгууллагууд дээр хэрэгжилт сул байгаа нь ажиглагдав. Сонирхолтой нь сүүлийн жилүүдэд иргэд ихээр үйлчлүүлэх болсон газар, ашигт малтмалыг зохицуулах газруудад сайн хэрэгжилттэй байсан.

Иргэд, хуулийн этгээдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хүргэдэг төрийн албан тушаалтны чиг үүрэг, эрх хэмжээ, ямар үйлчилгээг ямар хугацаанд үзүүлэх, бүрдүүлэх шаардлагатай материал зэргийг агуулсан танилцуулгыг үйлчлүүлэгчдэд тараах, эсхүл тэдэнд харагдахаар газарт бичиж тавих -2

Тус зөвлөмжөөр төрийн байгууллагууд нь иргэдтэй харилцах тодорхой албан тушаалтныхаа

1. Чиг үүрэг
2. Эрх хэмжээ
3. Ямар үйлчилгээг, ямар хугацаанд үзүүлэх
4. Иргэдийн бүрдүүлэх шаардлагатай материал

зэргийг агуулсан тараах материал эсвэл, танилцуулга гаргаж байрлуулах ёстой. Энэ дагуу судалгаа хийхэд нийт байгууллагуудын 23 хувь нь ямар нэг хэлбэрийн тараах материал, 49 хувь нь танилцуулга гаргаж самбартаа хадсан байлаа. Тараах материал, танилцуулгын агуулгад зөвлөмжийн дагуу шинжилгээ хийхэд иргэдэд үйлчилгээ үзүүлэх албан тушаалтны чиг үүргийг тус зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа бүх байгууллагууд танилцуулгадаа оруулсан бол 83 хувь нь албан тушаалтны эрх хэмжээг тусгасан, 81 хувь нь албан тушаалтнууд ямар үйлчилгээ үзүүлэх тухай тэмдэглэсэн, 87 хувь нь иргэдийн бүрдүүлж өгвөл зохих, шаардлагатай материалуудыг тэмдэглэжээ. Харин танилцуулгад албан тушаалтнууд хариуцсан үйлчилгээгээ ямар хугацаанд үзүүлэхийг 53 хувьд нь л заасан байгаа нь харьцангуй муу үзүүлэлт болж байна.

Мэдээллийг вэб сайтаар түгээхийн зэрэгцээ хэвлэмэл материал, тодорхой зөвлөгөө бүхий гарын авлага, зурагт хуудас гарган тараах-3

Судалгаанд хамруулсан төрийн байгууллагуудын 52 хувь нь вэб сайттай байсан бөгөөд, 36 хувь нь үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг хэвлэмэл материал тодорхой зөвлөгөө бүхий гарын авлага хэлбэрээр түгээж байсан. Бид байгууллагуудын өгсөн вэб сайтаар орж тандалт хийхэд 20 хүртэлх хувь нь эвдрэлтэй, ажиллахгүй байсан. Эрх хэмжээний хувьд дүүргүүд буюу анхан шатны

байгууллагууд дээр тус зөвлөмжийн хэрэгжилт сул байна. Харин нийслэл буюу дунд шатны байгууллагууд харьцангуй сайн үзүүлэлттэй байлаа. Үйл ажиллагааны төрлөөрөө санхүү, татвар, гааль; хяналт шалгалт, бүртгэл, мэдээлийн; мөрдөх, цагдан сэргийлэх байгууллагууд байгууллагууд дээрх харьцангуй сул хэрэгжилттэй байна. Харин бидний судалгаанд хамруулсан боловсролын байгууллагууд харьцангуй сайн явцтай байсан.

Иргэдийг хүлээн авч уулзах, цагийн хуваарь, уулзах ажилтны овог нэр, харилцах утсыг тодорхой бичиж, байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн самбарт болон вэб сайтад байрлуулах-4

Төрийн байгууллагуудын 64 хувь нь иргэдийг хүлээн авч, уулзах, цагийн хуваарийг гаргаж байгууллагын үйл ажиллагааны самбар /мөн вэб/-д байрлуулсан байсан бөгөөд 49 хувь нь иргэдтэй уулзах ажилтны овог, нэр харилцах утсыг бичиж тэмдэглэсэн байсан. Нийслэл буюу дунд түвшний байгууллагууд дээр иргэдийг хүлээн авч, уулзах, цагийн хуваарийг гаргах ажил харьцангуй сайн байсан ч яг уулзах ажилтны овог нэр, харилцах утас зэргийг бичиж тэмдэглэх талаар муухан байсан. Хяналт шалгалт, бүртгэл, мэдээлийн болон эрүүл мэндийн байгууллагуудад тус зөвлөмжийн хэрэгжилт харьцангуй сул байна.

Иргэд хүссэн мэдээллээ авч чадахгүй байгаа талаар гомдол, санал ирүүлсэн тохиолдолд холбогдох арга хэмжээ авах, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох механизмыг бий болгох-5

Иргэд хүссэн мэдээллээ авч чадахгүй байгаа талаар гомдол, санал ирүүлсэн тохиолдолд холбогдох арга хэмжээ авах, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох механизм нь нийт судалгаанд хамруулсан төрийн байгууллагуудын 75 хувьд байдаг байна. Байгууллагуудаар явж иргэдтэй хийсэн сурвалжлага, утасны мэдээлэл зэргээс үзвэл иргэдийн гомдол, саналыг хугацаанд шийдвэрлэж өгөхгүй удаах зэрэг асуудлууд дүүргийн газрын алба, цагдаагийн газар, засаг даргын тамгийн газрууд, шүүхүүдэд нэлээд тохиолддог байна. Өөрөөр хэлбэл хэдийгээр тухайн механизм нь байвч тэр нь ажиллахгүй байна.

Иргэд, хуулийн этгээдэд хэрэгцээтэй, тэдэнд хамаарах шийдвэрээ нийтэд вэб сайт болон бусад хэлбэрээр мэдээлж байх-6

Судалгаанд хамруулсан нийт байгууллагын 52 хувь болох өөрийн вэбтэй гэх байгууллага бүр иргэдэд хэрэгцээтэй мэдээлэл, шийдвэр бүрээ вэбээрээ мэдээллэдэг хэмээн хариулж байсан. Гэтэл гарсан шийдвэр, иргэдэд хамаатай мэдээллээ цаг хугацааны хувьд хожимдуулж гаргах, эсвэл бүр гаргахгүй байх явдал тохиолддог тухай иргэд ярьж байсан. Ялангуяа анхан шатны байгууллагууд дээр харьцангуй их тохиолддог байна.

Төрийн үйлчилгээний бүх төрлийн төлбөр, хураамжийг бодитой тогтоох, үндэслэлгүйгээр илүү болон нэмэгдэл төлбөр, хураамж авах асуудлыг таслэн зогсоох-7

Төрийн үйлчилгээний бүх төрлийн төлбөр, хураамжийг бодитой тогтоох, үндэслэлгүйгээр илүү болон нэмэгдэл төлбөр, хураамж авах асуудлыг таслан

зогсоох талаар төрийн байгууллагуудын 56 хувь нь ямар нэг байдлаар арга хэмжээ авч эхэлжээ. Энэ талаар иргэд, үйлчлүүлэгчдээс тодруулахад энэ асуудал хууль дүрмийн хүрээнд явдаг хэмээн 43 хувь нь хариулсан бол 7 хувь нь тодорхой бус байдлаар төлбөр авч байна гэжээ. Мөн утсаар хандсан иргэдийн 9 хувь нь төрийн байгууллагууд үндэслэлгүйгээр нэмэгдэл төлбөр авч байна хэмээн гомдол мэдүүлжээ. Энэ тал дээр эрүүл мэндийн байгууллагууд, боловсролын байгууллагууд, засаг даргын тамгын газрууд, цагдаагийн газрууд иргэдийн гомдол, шүүмжлэлд өртсөөр байна.

Байгууллагуудын удирдлагын шийдвэртэй холбогдох материал, төсвийн зарцуулалт, албан хаагчийн мэдээлэл /хөрөнгө орлогын мэдүүлэг гм/-ийг байгууллага бүр дотооддоо ил тод, нээлттэй болгох-8

Байгууллагын удирдлагын шийдвэртэй холбогдох материалыг судалгаанд хамруулсан нийт байгууллагуудын 62 хувь нь, байгууллагын төсвийн зориулалттай холбоотой мэдээллийг 38 хувь нь, байгууллагын албан хаагчийн мэдээлэл /хөрөнгө орлогын мэдүүлэг гм/-ийг 41 хувь нь дотооддоо ил тод, нээлттэй болгосон байна. Гадаад харилцаа; хяналт шалгалт, бүртгэл, мэдээлийн байгууллагууд; санхүү, татвар, гаалийн байгууллагууд; байгаль орчныг хариуцах байгууллагууд; эрүүл мэндийн байгууллагууд дээр хэрэгжилт сул байна.

Иргэдийн хэрэгцээт мэдээллийг вэб сайтдаа тавих, тавьсан мэдээллээ байнга шинэчилж байх-9

Судалгаанд хамруулсан нийт вэб сайттай гэх байгууллагуудын 21 хувь нь тогтмол мэдээллээ шинэчилдэг, 20 хувь нь ажиллагаагүй, 17 хувь нь шинэчлэл өөрчлөлт байхгүй, үлдсэн 45 хувь нь 2 сараас 2 жилийн өмнө л шинэчлэл хийсэн байлаа.

2. Авлигатай Тэмцэх Газраас төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй байдлыг сайжруулахаар хүргэсэн зөвлөмжийн хэрэгжилт

Үйл ажиллагааны нээлттэй байдлыг алдагдуулсан дүрэм, журмаа нягтлан үзэж өөрчлөх, хүчингүй болгох арга хэмжээ авах-10

Судалгаанд хамруулсан байгууллагуудын 45 хувь нь үйл ажиллагааныхаа нээлттэй байдлыг алдагдуулсан дүрэм, журмаа нягтлан үзэж өөрчлөх, хүчингүй болгох арга хэмжээ авч эхэлжээ. Тухайлбал судалгаанд хамруулсан байгууллагуудын 15 хувь нь иргэдийн бүрдүүлэх материалын тоо, дамжлагыг цөөрүүлсэн, 7 хувь нь энэ тал дээр санал боловсруулах шатандаа яваа зэрэг ахиц ажиглагдав. Боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд болон дүүргийн Тамгын газруудад тус зөвлөмжийн хэрэгжилт сул байна.

Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлж, иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг хуульд заасан хугацаанд түргэн шуурхай шийдвэрлэн хариуг өгөх-11

Иргэд, үйлчлүүлэгчдээс энэ талын мэдээллийг лавлахад 22 хувь нь үйлчилгээ нь /тухайн төрийн байгууллагын/ олон талаараа боломжийн, 12 хувь нь тухайн байгууллагын үйлчилгээ өмнөхөөсөө сайжирч байна, 5 хувь нь энэ асуудлыг хариуцсан тусгай нэг хүн байдаг гэх зэргээр харьцангуй эерэгээр хандсан байхад 32 хувь нь үйл ажиллагаа нь доголдолтой хэвээрээ байна, 30 хувь нь энэ талаар мэдэхгүй гэсэн үнэлэлтүүдийг өгсөн. Шүүх, прокурорын байгууллагууд; нийгмийн хөдөлмөр хамгаалал, даатгалын байгууллагуудад тус зөвлөмжийн хэрэгжилт сул байна.

Байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа нь тухайн байгууллагын ажилтнуудад нээлттэй байх, шийдвэрийн үндэслэлийн талаарх мэдээллийг иргэд, хуулийн этгээдэд нээлттэй болгох-12

Төрийн үйлчилгээг иргэдэд шууд хүргэх чиг үүрэг бүхий байгууллагын ажилтнуудын хувьд байгууллагынх нь шийдвэр гаргах үйл ажиллагаа нээлттэй байдаг хэмээн 79 хувь нь, зарим талаар нээлттэй байдаг хэмээн 10,6 хувь нь хариулсан бол 7,9 хувь нь нээлттэй бус хэмээн үзжээ. Шийдвэрийн үндэслэлийн талаарх мэдээлэл иргэдэд нээлттэй байх хэрэгтэй. Гэтэл үзэгчдийн бараг 68 хувь нь мэдэхгүй, байгууллагууд хэрэгжүүлдэггүй гэсэн хариултууд жин дарж байна, Харин нээлттэй байдаг хэмээн 29 хувь нь үзэж байна. Шүүх, прокурорын байгууллагууд; дэд бүтцийг хангах байгууллагууд; байгаль орчныг хариуцах байгууллагуудад; боловсролын байгууллагуудад тус зөвлөмжийн хэрэгжилт сул байв.

Төрийн байгууллага, албан тушаалтны ажиллагаанд ил тод байдлыг хэрхэн хангасан талаар жил бүр тайлан гаргаж дүгнэж байх-13

Төрийн байгууллагуудын 51 хувь нь албан тушаалтны ажиллагаанд ил тод байдлыг хэрхэн хангасан талаар тогтмол тайлан, 3.9 хувь нь нэмэлт тайлан, 26.6 хувь нь гаргасан тайлангаа дүгнэдэг бол 6.9 хувь нь энэ асуудлыг тодорхой нэг албан тушаалтандаа хариуцуулдаг ажээ. Харин 2.5 хувь нь төрийн байгууллагын албан тушаалтны үйл ажиллагаа нээлттэй, ил тод, бүгд явцын хуралд суудаг учир тайлан гаргах шаардлагагүй, 0.5 хувь нь тайлан гаргадаггүй зэрэг хариултуудыг өгчээ. Боловсролын байгууллагууд; Нийгмийн хөдөлмөр хамгаалал, даатгалын байгууллагууд; дэд бүтцийг хангах байгууллагууд; хүнс, худалдаа үйлдвэрлэлийн байгууллагууд; гадаад харилцааны байгууллагуудад тус зөвлөмжийн хэрэгжилт сул байв.

3. Авлигатай Тэмцэх Газраас төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах чиглэлээр хүргэсэн зөвлөмжийн хэрэгжилт

Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн байгууллагад иргэд чөлөөтэй нэвтрэх боломжийг бүрдүүлэх-14

Төрийн байгууллагуудаас үйлчилгээ авч байсан иргэдийн 80 хувь нь тухайн байгууллагад нэвтрэхэд нь ямар нэгэн саад байдаггүй гэсэн байхад 15 хувь нь дүрэм журамд заасных нь дагуу шаардлагатай бичиг баримт /ихэнх тохиолдолд биеийн байцаалт/ -аас шалгуулж орсон байна. Харин 5 хувь нь ороход нь бэрхшээлтэй бэрхшэлтэй эсвэл орж чаддаггүй гэсэн хариулт өгчээ.

Иргэдээс мэдээлэл хүлээн авах утас ажиллуулах, эсхүл санал хүсэлтийн хайрцаг/дэвтэр/-ийг байрлуулан иргэдийн санал, хүсэлтийг авч, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авч ажиллах-15

Иргэдэд үйлчлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын 60 хувь нь иргэдээс мэдээлэл хүлээн авах утас ажиллуулдаг хэмээн судалгаанд хариулт өгсөн юм. Үүнийг бид үйлчлүүлэгч иргэдээс тодорлуулахад нийт иргэд, үйлчлүүлэгчдийн 6 хувь нь л утсаар хандаж байсан байх юм. 36 хувь нь ажиллуулдаг гэдгийг нь мэдэх боловч хандаж байгаагүй, 57 хувь нь ажиллуулдаггүй буюу мэдэхгүй гэж хариулсан. Нийгмийн хөдөлмөр хамгаалал, даатгалын байгууллагууд; хяналт шалгалт, бүртгэл, мэдээлийн байгууллагууд; тамгын газаруудад хэрэгжилт сул байв.

Мөн дээрх байгууллагуудын 37 хувь нь санал хүсэлтийн хайрцаг ажиллуулдаг байна. Гэтэл үйлчлүүлэгч иргэдийнх нь 1 хувь нь ашиглаж байсан, 16 хувь нь байдаг гэдгийг нь мэдэх хэдий ч ашиглаж байгаагүй, 83 хувь нь ашиглаж байгаагүй ба мэдэхгүй гэсэн хариулт өгсөн. Гадаад харилцааны байгууллагууд; дэд бүтцийг хангах байгууллагуудад хэрэгжилт сул байв.

Байгууллагуудын 26 хувь нь дэвтэр гаргаж ажиллуулдаг байна. Гэтэл иргэдийн 2 хувь нь л түүнийг ашиглаж байсан, 26 хувь нь ажиглуулдаг гэдгийг мэдэх хэдий ч ашиглаж байгаагүй, 78 хувь нь ажиллуулдаггүй ба мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр даатгалын байгууллагууд; боловсролын байгууллагууд; газар, ашигт малтмалыг зохицуулах байгууллагуудад хэрэгжилт сул байв.

Мөн нийт байгууллагуудын 69 хувь нь иргэдээс мэдээлэл хүлээн авах утас /санал хүсэлтийг хайрцаг/дэвтэр//ийг байгууллагад байрлуулж иргэдийн санал, хүсэлтийг авч, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авдаг механизм байдаг хэмээн өгүүлсэн. Шүүх, прокурорын байгууллагуудад байгууллагуудад хэрэгжилт сул байв.

Төрийн байгууллага тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн санал бодлыг авч, анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох-16

Төрийн байгууллагуудын хувьд 51 хувь нь тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн саналыг авдаг, 60 хувь нь олон нийтийн саналыг авдаг бөгөөд анхаарал татаж байгаа мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгадаг гэсэн хариулт өгсөн юм. Тогтмол түүнд нь оролцож байсан иргэд үйлчлүүлэгчдийн 4 хувь, зарим тохиолдолд оролцож байсан иргэд 5.4 хувь болж байгаа бол 40 хувь нь мэдэхгүй, огт оролцож байгаагүй байна. Гадаад харилцааны байгууллагууд; Шүүх, прокурорын байгууллагууд; Хүнс, худалдаа үйлдвэрлэлийн байгууллагуудад байгууллагуудад хэрэгжилт сул байв.

Тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, тэдгээртэй танилцах боломжоор хангах-17

Хууль тогтоомжид тус байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шаргаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хориглосон байдаг байгууллагууд 8 хувь нь, зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг олон нийтэд ил тод байлгаж, танилцах боломжоор хангасан байгууллагууд 92 хувь нь байлаа. Гадаад харилцааны байгууллагууд; Газар, Ашигт малтмалыг зохицуулах байгууллагууд; Мөрдөх, цагдан сэргийлэх байгууллагууд; тамгын газруудад хэрэгжилт сул байна.

Мөн тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг олон нийтэд ил тод нээлттэй байлгадаг гэж иргэдийн 19 хувь нь, 33 хувь нь өмнөхөө бодвол сайжирсан, 33 хувь нь нээлттэй биш, 45 хувь нь мэдэхгүй гэсэн үнэлгээ өгсөн. Шүүх, прокурорын байгууллагууд; Нийгмийн хөдөлмөр хамгаалал, даатгалын байгууллагууд; Мөрдөх, цагдан сэргийлэх байгууллагуудад хэрэгжилт сул байна.

Байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрмийг боловсронгуй болгож, тэр дундаа ямар ёс зүйг ажилтнууд сахих талаарх заалтуудыг иргэдэд нээлттэй болгох-18

Төрийн үйлчилгээг иргэдэд шууд хүргэх чиг үүрэг бүхий байгууллагуудын 55 хувь нь ажилтнуудынхаа ёс зүйн заалтуудыг иргэдэд нээлттэй болгосон байна. Иргэд, үйлчлүүлэгчдийн 16 хувь нь ажилчдын иргэдтэй харьцах харьцаа нь сайн, ажилтнуудын ёс зүй нээлттэй ил тод байдаг; 46.5 хувь нь хаалттай, 27 хувь нь мэдэхгүй хэмээн хариулсан байна. Гадаад харилцааны байгууллагууд; Эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжилт сул байна.

4. Дүгнэлт

- Төрийн үйлчилгээг иргэдэд шууд хүргэх чиг үүрэг бүхий байгууллагууд дээр АТГ-аас хүргүүлсэн 18 зүйл заалт бүхий зөвлөмжийг хэрэгжүүлэх суурь боломж ерөнхийдөө байгаа юм. Тодруулбал зөвлөмжид тусгасан байгууллагуудын мэдээллийн хүртээмжтэй байдал, ил тод нээлттэй байдал, иргэдийн оролцоог хангах механизмыг бүрдүүлж буй гол элементүүд байна. Суурь боломжийг процентоор ойролцоолон илэрхийлбэл 55 хувьтай байна. Гэхдээ энэ тоо зөвхөн механизмыг илэрхийлэх тул механизмын ажиллагааг бүрэн утгаараа илэрхийлэхгүй болно. Үүний нэг жишээ нийт байгууллагуудын 52 хувь нь вэб сайттай байгаа боловч тэдгээр байгууллагуудын 21 хувь нь л тогтмол мэдээллээ шинэчилдэг, дээр нь нийт вэб сайтын 20 хувь нь ажиллагаагүй, 17 хувь нь шинэчлэл өөрчлөлт байхгүй, үлдсэн 45 хувь нь 2 сараас 2 жилийн өмнөх мэдээлэлтэйгээ байв.
- 2007 оны 4 сард хүргэсэн АТГ-ын зөвлөмж мартагдах дөхжээ. Зөвлөмжийг хүргэсэн гэх зарим газаруудад тус зөвлөмжийн талаар огт сонсоогүй албан хаагчид их байсан. Төрийн байгууллагууд нь өөрөө хатуу бюрократ бүтэцтэй байдаг бөгөөд байгууллага дахь ямарваа статус бүр өөр өөрийн үүрэгтэй. Иймд тухайн байгууллагад албан ёсны статусгүй зөвлөмж нь ажил үүргийн явцад сугарч үлдэх мартагдаж байгаа жишээ цөөнгүй байна. Тиймээс байгууллага бүрд АТГ-ын зөвлөмжийн хэрэгжилтийг дор хаяж нэг албан хаагчид албан ёсны үүрэг хэлбэрээр давхар хариуцах нь зүйтэй.
- АТГ хүргүүлсэн зөвлөмжийнхөө хэрэгжилтийг хянах, хэрэгжилтгүй байгууллагуудад анхааруулга өгөх зэргээр идэвхтэй ажиллах нь зөв. Учир нь хяналтын систем байхгүй байна.
- Зөвлөмж хэрэгжихгүй байгаа, тухайлбал 1977 шууд утсаар гомдол, санал ихээхэн авч байгаа дүүргүүдийн газрын албад, бүх шатны шүүхүүд зэрэг байгууллагуудад төвлөрч ажиллах, тухайлбал, ХХҮГ, ЭМБ, БГ зэрэг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтан, хэлтэс, салбарын дарга нар болон бүх шатны шүүгч, прокурор, мэргэжлийн хяналтын байцаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, цагдаа, гаалийн байцаагч зэрэг иргэдтэй шууд тулж ажилладаг төр захиргааны гүйцэтгэх албан тушаалтнууд, төрийн тусгай байгууллагын албан тушаалтнуудын үйл ажиллагаатай холбоотой гомдлууд үнэмлэхүй хувийг эзэлж байгаад дурьдагдсан байгууллага, албан тушаалтнууд анхааралдаа авч, үйл ажиллагаагаа сайжруулах нь зүйтэй.

ХАВСРАЛТ -1**Мэдээлэл хүртээмжтэй байх талаар****Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэг бүхий байгууллага өөрийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журмаа үйлчлүүлэгчдэд харагдахаар газарт байрлуулах -1**

| | Улс | Нийслэл | Дүүрэг | Бүгд |
|--|-------|---------|--------|-------|
| Санхүү, татвар, гаалийн байгууллагууд | 25,0 | 0,0 | 66,7 | 41,7 |
| Гадаад харилцааны байгууллагууд | 50,0 | | | 50,0 |
| Шүүх, прокурорын байгууллагууд | 25,0 | 0,0 | 73,3 | 54,5 |
| Нийгмийн хөдөлмөр хамгаалал, даатгалын байгууллагууд | 66,7 | 100,0 | 18,2 | 37,5 |
| Дэд бүтцийг хангах байгууллагууд | 33,3 | | | 33,3 |
| Байгаль орчныг хариуцах байгууллагууд | 100,0 | | | 100,0 |
| Боловсролын байгууллагууд | 100,0 | 0,0 | | 50,0 |
| Хүнс, худалдаа үйлдвэрлэлийн байгууллагууд | 50,0 | | | 50,0 |
| Эрүүл мэндийн байгууллагууд | 37,5 | 0,0 | | 33,3 |
| Газар, Ашигт малтмалыг зохицуулах байгууллагууд | 100,0 | 100,0 | 100,0 | 100,0 |
| Мөрдөх, цагдан сэргийлэх байгууллагууд | 66,7 | | 75,0 | 72,2 |
| Хяналт шалгалт, бүртгэл, мэдээлийн байгууллагууд | 66,7 | 0,0 | | 57,1 |
| Бусад | 100,0 | 0,0 | 66,7 | 62,5 |
| Нийт | 53,5 | 25,0 | 61,5 | 54,2 |

Жич: Дээрх хүснэгтийг уншихдаа санхүү, татвар, гаалийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагуудын 41.7 хувь нь үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм журмаа үйлчлүүлэгчдэд харагдахаар газарт байрлуулсан ба тэдгээрийн улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагуудын 25.0 хувь, дүүргийн хэмжээнд 66.7 хувь нь тус тус дүрэм журмаа үйлчлүүлэгчдэд харагдахаар газарт байрлуулсан байна. Мөн улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг нийт байгууллагуудын 53.5 хувь, нийслэлийн 25.0 хувь, дүүргүүдийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг нийт байгууллагуудын 61.5 хувь нь дүрэм журмаа үйлчлүүлэгчдэд харагдахаар газарт байрлуулсан ба нийт төрийн байгууллагуудын 54.2 хувь нь зөвлөмж -1-ийг хэрэгжүүлсэн байна гэж уншина. ХАВСРАЛТ-1-ийн тооцооллуудыг бүгдийг ийм зарчмаар уншина.

Иргэд, хуулийн этгээдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хүргэдэг төрийн албан тушаалтны чиг үүрэг, эрх хэмжээ, ямар үйлчилгээг ямар хугацаанд үзүүлэх, бүрдүүлэх шаардлагатай материал зэргийг агуулсан танилцуулгыг үйлчлүүлэгчдэд тараах, эсхүл тэдэнд харагдахаар газарт бичиж тавих -2

2.1 Иргэд, хуулийн этгээдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хүргэдэг төрийн албан тушаалтны чиг үүрэг, эрх хэмжээ, ямар үйлчилгээг ямар хугацаанд үзүүлэх, бүрдүүлэх шаардлагатай материал зэргийг агуулсан танилцуулгыг үйлчлүүлэгчдэд тарааж байна уу

| | Улс | Нийслэл | Дүүрэг | Бүгд |
|--|-------|---------|--------|------|
| Санхүү, татвар, гаалийн байгууллагууд | 25,0 | 0,0 | 33,3 | 25,0 |
| Гадаад харилцааны байгууллагууд | 0,0 | | | 0,0 |
| Шүүх, прокурорын байгууллагууд | 0,0 | 33,3 | 26,7 | 22,7 |
| Нийгмийн хөдөлмөр хамгаалал, даатгалын байгууллагууд | 33,3 | 50,0 | 36,4 | 37,5 |
| Дэд бүтцийг хангах байгууллагууд | 33,3 | | | 33,3 |
| Байгаль орчныг хариуцах байгууллагууд | 0,0 | | | 0,0 |
| Боловсролын байгууллагууд | 0,0 | 0,0 | | 0,0 |
| Хүнс, худалдаа үйлдвэрлэлийн байгууллагууд | 50,0 | | | 50,0 |
| Эрүүл мэндийн байгууллагууд | 25,0 | 0,0 | | 22,2 |
| Газар, Ашигт малтмалыг зохицуулах байгууллагууд | 0,0 | 100,0 | 0,0 | 20,0 |
| Мөрдөх, цагдан сэргийлэх байгууллагууд | 33,3 | | 8,3 | 16,7 |
| Хяналт шалгалт, бүртгэл, мэдээлийн байгууллагууд | 16,7 | 0,0 | | 14,3 |
| Бусад | 100,0 | 0,0 | 16,7 | 25,0 |
| Нийт | 23,3 | 25,0 | 23,1 | 23,4 |

2.2 Иргэд, хуулийн этгээдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хүргэдэг төрийн албан тушаалтны чиг үүрэг, эрх хэмжээ, ямар үйлчилгээг ямар хугацаанд үзүүлэх, бүрдүүлэх шаардлагатай материал зэргийг агуулсан танилцуулгыг үйлчлүүлэгчдэд тарааж байна уу

| | Улс | Нийслэл | Дүүрэг | Бүгд |
|--|-------|---------|--------|-------|
| Санхүү, татвар, гаалийн байгууллагууд | 25,0 | 0,0 | 66,7 | 41,7 |
| Гадаад харилцааны байгууллагууд | 0,0 | | | 0,0 |
| Шүүх, прокурорын байгууллагууд | 50,0 | 33,3 | 60,0 | 54,5 |
| Нийгмийн хөдөлмөр хамгаалал, даатгалын байгууллагууд | 100,0 | 50,0 | 18,2 | 37,5 |
| Дэд бүтцийг хангах байгууллагууд | 33,3 | | | 33,3 |
| Байгаль орчныг хариуцах байгууллагууд | 100,0 | | | 100,0 |
| Боловсролын байгууллагууд | 100,0 | 0,0 | | 50,0 |
| Хүнс, худалдаа үйлдвэрлэлийн байгууллагууд | 50,0 | | | 50,0 |
| Эрүүл мэндийн байгууллагууд | 37,5 | 100,0 | | 44,4 |
| Газар, Ашигт малтмалыг зохицуулах байгууллагууд | 50,0 | 100,0 | 100,0 | 80,0 |
| Мөрдөх, цагдан сэргийлэх байгууллагууд | 50,0 | | 66,7 | 61,1 |
| Хяналт шалгалт, бүртгэл, мэдээлийн | 33,3 | 100,0 | | 42,9 |

| | | | | |
|---------------|-------|------|------|------|
| байгууллагууд | | | | |
| Бусад | 100,0 | 0,0 | 50,0 | 50,0 |
| Нийт | 46,5 | 41,7 | 53,8 | 49,5 |

2.3 Танилцуулгад албан тушаалтнуудын чиг үүргийг заажээ

| | Улс | Нийслэл | Дүүрэг | Бүгд |
|--|-------|---------|--------|-------|
| Санхүү, татвар, гаалийн байгууллагууд | 0,0 | 100,0 | 75,0 | 66,7 |
| Шүүх, прокурорын байгууллагууд | 50,0 | | 77,8 | 72,7 |
| Нийгмийн хөдөлмөр хамгаалал, даатгалын байгууллагууд | 100,0 | 100,0 | 100,0 | 100,0 |
| Дэд бүтцийг хангах байгууллагууд | 100,0 | | | 100,0 |
| Байгаль орчныг хариуцах байгууллагууд | 0,0 | | | 0,0 |
| Боловсролын байгууллагууд | 100,0 | | | 100,0 |
| Хүнс, худалдаа үйлдвэрлэлийн байгууллагууд | 0,0 | | | 0,0 |
| Эрүүл мэндийн байгууллагууд | 66,7 | 0,0 | | 50,0 |
| Газар, Ашигт малтмалыг зохицуулах байгууллагууд | 100,0 | 100,0 | 0,0 | 50,0 |
| Мөрдөх, цагдан сэргийлэх байгууллагууд | 100,0 | | 75,0 | 81,8 |
| Хяналт шалгалт, бүртгэл, мэдээлийн байгууллагууд | 100,0 | 0,0 | | 66,7 |
| Бусад | 100,0 | | 100,0 | 100,0 |
| Нийт | 75,0 | 60,0 | 75,0 | 73,6 |

2.4 Танилцуулгад албан тушаалтнуудын эрх хэмжээг тусгажээ

| | Улс | Нийслэл | Дүүрэг | Бүгд |
|--|-------|---------|--------|-------|
| Санхүү, татвар, гаалийн байгууллагууд | 0,0 | | 50,0 | 40,0 |
| Шүүх, прокурорын байгууллагууд | 50,0 | 0,0 | 77,8 | 66,7 |
| Нийгмийн хөдөлмөр хамгаалал, даатгалын байгууллагууд | 100,0 | 100,0 | 50,0 | 83,3 |
| Дэд бүтцийг хангах байгууллагууд | 100,0 | | | 100,0 |
| Байгаль орчныг хариуцах байгууллагууд | 0,0 | | | 0,0 |
| Боловсролын байгууллагууд | 0,0 | | | 0,0 |
| Хүнс, худалдаа үйлдвэрлэлийн байгууллагууд | 0,0 | | | 0,0 |
| Эрүүл мэндийн байгууллагууд | 66,7 | 0,0 | | 50,0 |
| Газар, Ашигт малтмалыг зохицуулах байгууллагууд | 100,0 | 100,0 | 0,0 | 50,0 |
| Мөрдөх, цагдан сэргийлэх байгууллагууд | 100,0 | | 62,5 | 72,7 |
| Хяналт шалгалт, бүртгэл, мэдээлийн байгууллагууд | 100,0 | 0,0 | | 66,7 |
| Бусад | 0,0 | | 66,7 | 50,0 |
| Нийт | 65,0 | 40,0 | 60,7 | 60,4 |

2.5 Танилцуулгад албан тушаалтнууд ямар үйлчилгээ үзүүлэх тухай тэмдэглэжээ

| | Улс | Нийслэл | Дүүрэг | Бүгд |
|--|-------|---------|--------|-------|
| Санхүү, татвар, гаалийн байгууллагууд | 100,0 | | 100,0 | 100,0 |
| Шүүх, прокурорын байгууллагууд | 0,0 | 0,0 | 77,8 | 58,3 |
| Нийгмийн хөдөлмөр хамгаалал, даатгалын байгууллагууд | 66,7 | 100,0 | 50,0 | 66,7 |
| Дэд бүтцийг хангах байгууллагууд | 100,0 | | | 100,0 |
| Байгаль орчныг хариуцах байгууллагууд | 100,0 | | | 100,0 |
| Боловсролын байгууллагууд | 0,0 | | | 0,0 |
| Хүнс, худалдаа үйлдвэрлэлийн байгууллагууд | 0,0 | | | 0,0 |
| Эрүүл мэндийн байгууллагууд | 66,7 | 0,0 | | 50,0 |
| Газар, Ашигт малтмалыг зохицуулах байгууллагууд | 100,0 | 100,0 | 50,0 | 75,0 |
| Мөрдөх, цагдан сэргийлэх байгууллагууд | 100,0 | | 75,0 | 81,8 |
| Хяналт шалгалт, бүртгэл, мэдээлийн байгууллагууд | 50,0 | 0,0 | | 33,3 |
| Бусад | 100,0 | | 100,0 | 100,0 |
| Нийт | 65,0 | 40,0 | 78,6 | 69,8 |

2.6 Танилцуулгад албан тушаалтнууд хариуцсан үйлчилгээгээ ямар хугацаанд үзүүлэхийг заажээ

| | Улс | Нийслэл | Дүүрэг | Бүгд |
|--|-------|---------|--------|-------|
| Санхүү, татвар, гаалийн байгууллагууд | 0,0 | | 25,0 | 20,0 |
| Шүүх, прокурорын байгууллагууд | 50,0 | 0,0 | 66,7 | 58,3 |
| Нийгмийн хөдөлмөр хамгаалал, даатгалын байгууллагууд | 0,0 | 100,0 | 0,0 | 16,7 |
| Дэд бүтцийг хангах байгууллагууд | 100,0 | | | 100,0 |
| Байгаль орчныг хариуцах байгууллагууд | 0,0 | | | 0,0 |
| Боловсролын байгууллагууд | 100,0 | | | 100,0 |
| Хүнс, худалдаа үйлдвэрлэлийн байгууллагууд | 100,0 | | | 100,0 |
| Эрүүл мэндийн байгууллагууд | 66,7 | 0,0 | | 50,0 |
| Газар, Ашигт малтмалыг зохицуулах байгууллагууд | 0,0 | 100,0 | 50,0 | 50,0 |
| Мөрдөх, цагдан сэргийлэх байгууллагууд | 66,7 | | 50,0 | 54,5 |
| Хяналт шалгалт, бүртгэл, мэдээлийн байгууллагууд | 0,0 | 0,0 | | 0,0 |
| Бусад | 0,0 | | 66,7 | 50,0 |
| Нийт | 40,0 | 40,0 | 50,0 | 45,3 |

2.7 Танилцуулгад албан тушаалтнуудад иргэдийн бүрдүүлж өгвөл зохих, шаардлагатай материалуудыг тэмдэглэжээ

| | Улс | Нийслэл | Дүүрэг | Бүгд |
|--|-------|---------|--------|-------|
| Санхүү, татвар, гаалийн байгууллагууд | 100,0 | | 75,0 | 80,0 |
| Шүүх, прокурорын байгууллагууд | 100,0 | 100,0 | 77,8 | 83,3 |
| Нийгмийн хөдөлмөр хамгаалал, даатгалын байгууллагууд | 33,3 | 100,0 | 50,0 | 50,0 |
| Дэд бүтцийг хангах байгууллагууд | 100,0 | | | 100,0 |
| Байгаль орчныг хариуцах байгууллагууд | 100,0 | | | 100,0 |
| Боловсролын байгууллагууд | 100,0 | | | 100,0 |
| Хүнс, худалдаа үйлдвэрлэлийн байгууллагууд | 100,0 | | | 100,0 |
| Эрүүл мэндийн байгууллагууд | 66,7 | 0,0 | | 50,0 |
| Газар, Ашигт малтмалыг зохицуулах байгууллагууд | 0,0 | 100,0 | 50,0 | 50,0 |
| Мөрдөх, цагдан сэргийлэх байгууллагууд | 66,7 | | 100,0 | 90,9 |
| Хяналт шалгалт, бүртгэл, мэдээлийн байгууллагууд | 0,0 | 0,0 | | 0,0 |
| Бусад | 100,0 | | 66,7 | 75,0 |
| Нийт | 65,0 | 60,0 | 78,6 | 71,7 |

